

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

Үнийн санал ирүүлэхдээ дараах материалыг ирүүлнэ. Үүнд:

1. Байгууллагын танилцуулга
2. Улсын бүртгэлийн гэрчилгээ, нотариатаар баталгаажуулсан хуулбар (үнийн санал авах урилга нийтлэгдсэн өдрөөс хойш байх)
3. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, нотариатаар баталгаажуулсан хуулбар, (үнийн санал авах урилга нийтлэгдсэн өдрөөс хойш байх)
4. Харуул хамгаалалтын ажил гүйцэтгэсэн туршлагатай байх (гэрээний хуулбарыг хавсаргах)
5. 2021, 2022 оны санхүүгийн тайлан
6. Тоног төхөөрөмж, хүний нөөцийн чадавхийн мэдээлэл
7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт (үнийн санал авах урилга нийтлэгдсэн өдрөөс хойш байх)

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Объект:

Улаанбаатар хот Сүхбаатар дүүргийн 1-р хороо Энхтайваны өргөн чөлөө-1, Эмгэг судлалын үндэсний төв.

Доорх объектын зурагны 2 дугаар давхарын хэсэг нь Эмгэг судлалын үндэсний төв болно.



Хийх ажил:

- Үндсэн үйл ажиллагааны дагуу:
Эмгэг судлалын үндэсний төвийн эзэмшлийн 785,12 мкв талбайд байрлах объектыг гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хорлон сүйтгэх, гал түймэр, хулгай, дээрэм бусад аюулын мэдээг зохих байгууллагад цаг алдалгүй мэдээлэх, шаардлагатай арга хэмжээ авч гэрээт харуул хамгаалалтын үндсэн үйл ажиллагааг 24 цагийн турш тасралтгүй хийж гүйцэтгэх.
- Нэмэлт хийх ажил:
 - Шаардлагатай үед байгууллагын дотоод үйл ажиллагаанд оролцох /үйлчлүүлэгчдэд үйлчилгээний талаар мэдээлэл өгөх, оочир дараалал, эмх замбараагүй байдлыг зохицуулах, шаардлагатай тохиолдолд өвчтөн, бараа материал, тоног төхөөрөмж г.м зөөх/
 - Гадна авто машины зогсоолд үйлчлүүлэгчдийн ар гэрийн болон ажилтнуудын машиныг эмх цэгцтэй зогсоож 103 буюу түргэн тусламжийн авто машин зогсох чөлөөтэй нэвтрэх нөхцөл бололцоогоор хангах.

Харуул хамгаалалтын компани нь:

- Харуул хамгаалалтын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөлтэй, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан, хүний нөөц, санхүүгийн чадавхитай байгууллага байна.
- Харуул хамгаалалтын ажилтан нь харуул хамгаалалтын сургалтанд суусан, шаардлагатай тоног төхөөрөмж, хувцас хэрэгсэл хангагдсан байна.